

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр

Тендерийн нэр: “Геологи хайгуулын өрөмдлөг, технологийн судалгааны үр дүнгээр нөөцийн тодотгол тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх”

Тендер дугаар: МРЦМ/202212224

“Монголросцветмет” ТӨҮГазар нь өөрийн хайлуур жоншны орд газрууд болох Өргөний 8-р хүдрийн биет (MV-013440) болон Баруун баргын овоо (MV-000160) талбайд геологи хайгуулын өрөмдлөг, технологийн судалгааны үр дүнгээр нөөцийн тодотгол тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх ажлын зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь тус үйлдвэрийн газрын хайлуур жоншны зарим орд газруудын нөөцийг шинэчлэн тогтоох, олборлолтын ажиллагаанд оруулах бэлтгэлийг хангахад чиглэгдэнэ.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан талаарх дараах нотлох баримтыг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2019, 2020, 2021 онуудын аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна.
- Голлох мэргэжилтний чадавхийн талаарх мэдээлэл: Ажиллах боловсон хүчний ур чадвар, мэргэшил, туршлага
- Татвар, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын тодорхойлолтууд (татварын дутуу төлөлт өргүй болон өр төлбөргүй байх)
- Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2019, 2020, 2021 (Сүүлийн гурван жилд ижил төстэй хийж гүйцэтгэсэн зөвлөх үйлчилгээний ажлыг жагсаалт, гэрээний хуулбарыг гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ)
- Тухайн тендерт заагдсан геологи хайгуул, технологийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд ашиглах техник, тоног төхөөрөмжийн мэдээлэл

Чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөхүүд түншлэл, туслан гүйцэтгэгчийн хэлбэрээр оролцож болно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс авч болох бөгөөд тендерийн нэмэлт мэдээлэл, тодруулгыг Захиалагч www.tender.gov.mn хаягаар цахим хэлбэрээр хүлээн авна.

Тендерт оролцогч мэдүүлгээ 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 10:00 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГазар